



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 07 сарын 24 өдөр

Дугаар 09

Улаанбаатар хот


Үндэсний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэх зорилгоор салбарын үйл ажиллагааны уялдаа холбоог хангаж, нэгдсэн удирдлагаар хангах үүрэг бүхий "Алсын хараа 2050" салбар дундын уялдааг хангах Үндэсний хороог байгуулж, Үндэсний хорооны бүрэлдэхүүнийг 1 дүгээр хавсралт, Үндэсний хорооны ажиллах журмыг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. "Алсын хараа 2050" салбар дундын уялдааг хангах Үндэсний хорооны Ажлын албаны орон тооны хязгаарыг 15 байхаар тогтоосугай.

3. Энэ тогтоолын 2-т заасан Ажлын албаны үйл ажиллагааны зардлыг Монгол Улсын 2024 оны төсвийн тодотголд тусгаж, цаашид жил бүрийн улсын төсөвт тусгах арга хэмжээ авахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Сангийн сайд Б.Жавхлан нарт даалгасугай.



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА

Н.УЧРАЛ



Засгийн газрын 2024 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн 09 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт

"АЛСЫН ХАРАА 2050" САЛБАР ДУНДЫН УЯЛДААГ ХАНГАХ ҮНДЭСНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

- Дарга: -Монгол Улсын Ерөнхий сайд.
- Гишүүд: -Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд;
- Монгол Улсын Шадар сайд (гадаад худалдаа, хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан);
- Монгол Улсын Шадар сайд (бүсчилсэн хөгжил, онцгой байдлын асуудал хариуцсан);
- Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга;
- Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны дарга;
- Гадаад харилцааны сайд;
- Сангийн сайд;
- Хууль зүй, дотоод хэргийн сайд;
- Батлан хамгаалахын сайд;
- Боловсролын сайд;
- Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд;
- Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд;
- Ч.Анар-Улсын Их Хурлын гишүүн (зөвшилцсөнөөр);
- Ж.Баясгалан-Улсын Их Хурлын гишүүн (зөвшилцсөнөөр);
- П.Ганзориг-Улсын Их Хурлын гишүүн (зөвшилцсөнөөр);
- А.Ганбаатар-Улсын Их Хурлын гишүүн (зөвшилцсөнөөр);
- Б.Жаргалан-Улсын Их Хурлын гишүүн (зөвшилцсөнөөр);
- Г.Лувсанжамц-Улсын Их Хурлын гишүүн (зөвшилцсөнөөр);

- Б.Найдалаа-Улсын Их Хурлын гишүүн (зөвшилцсөнөөр);
 - О.Номинчимэг-Улсын Их Хурлын гишүүн (зөвшилцсөнөөр);
 - Б.Пунсалмаа-Улсын Их Хурлын гишүүн (зөвшилцсөнөөр);
 - О.Саранчулуун-Улсын Их Хурлын гишүүн (зөвшилцсөнөөр);
 - Х.Тэмүүжин-Улсын Их Хурлын гишүүн (зөвшилцсөнөөр);
 - Б.Уянга-Улсын Их Хурлын гишүүн (зөвшилцсөнөөр);
 - С.Цэнгүүн-Улсын Их Хурлын гишүүн (зөвшилцсөнөөр);
 - М.Энхцэцэг-Улсын Их Хурлын гишүүн (зөвшилцсөнөөр);
 - Монгол Улсын Ерөнхий сайдын Ахлах зөвлөх;
 - “Шинэ сэргэлтийн бодлогын Хурдасгуур төв”-ийн захирал.
- Нарийн бичгийн дарга: -Д.Ганмаа-Улсын Их Хурлын гишүүн (зөвшилцсөнөөр).

----o0o----



Засгийн газрын 2024 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн 09 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт

“АЛСЫН ХАРАА 2050” САЛБАР ДУНДЫН УЯЛДААГ ХАНГАХ ҮНДЭСНИЙ ХОРООНЫ АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.“Алсын хараа 2050” салбар дундын уялдааг хангах Үндэсний хороо (цаашид “Үндэсний хороо” гэх)-ны үйл ажиллагааг энэ журмаар зохицуулна.

1.2.Үндэсний хороо нь “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэх суурь нөхцөлийг бүрдүүлэх, Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Засгийн газрын үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлд тусгагдсан төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор салбарын үйл ажиллагааны уялдааг хангаж, нэгдсэн бодлого, зохицуулалтаар уялдуулан зохицуулах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ.

1.3.Үндэсний хороо нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, бусад хууль тогтоомж болон энэ журмыг удирдлага болгоно.

1.4.Үндэсний хороо нь тогтоосон журмын дагуу үйлдсэн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

Хоёр.Хорооны бүрэлдэхүүн, бүрэн эрх, үйл ажиллагааны зохион байгуулалт

2.1.Үндэсний хороог Монгол Улсын Ерөнхий сайд тэргүүлж, удирдана.

2.2.Монгол Улсын Ерөнхий сайдын түр эзгүйд түүний үүрэг болгосноор Үндэсний хорооны аль нэг гишүүн хороог удирдана.

2.3.Үндэсний хорооны бүрэлдэхүүнд зөвшилцсөний үндсэн дээр Улсын Их Хурлын гишүүнийг оролцуулж болно.

2.4.Үндэсний хороо дараах бүрэн эрхтэй:

2.4.1.Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн явцын талаар мэдээлэл сонсож, үүрэг чиглэл өгөх;

2.4.2.салбарын яамдаас хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн явц, үр дүнтэй танилцаж, уялдуулан зохицуулах;

2.4.3.төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор салбар дундын зохицуулалт хийх, хугацаатай үүрэг, даалгавар өгөх, үр дүнг тооцох;

2.4.4. Засгийн газрын тэргүүлэх чиглэлийн бодлогын асуудлыг хариуцсан Дэд хорооны үйл ажиллагааны талаар мэдээлэл, саналыг сонсож, үүрэг чиглэл өгөх.

2.5. Үндэсний хорооны үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байх бөгөөд шаардлагатай тохиолдолд цахимаар зохион байгуулж болно.

2.6. Үндэсний хороо улиралд 1 удаа хуралдана. Шаардлагатай тохиолдолд Монгол Улсын Ерөнхий сайдын санаачилгаар ээлжит бус хуралдааныг хуралдуулж болно.

2.7. Үндэсний хорооны хуралдааныг нийт гишүүдийн олонх оролцсоноор хүчинтэйд тооцно.

2.8. Үндэсний хорооны хуралдааны дэгийг Монгол Улсын Ерөнхий сайд батална.

Гурав. Үндэсний хорооны шийдвэр

3.1. Үндэсний хорооны хуралдаанаар хэлэлцсэн асуудлыг хуралдаанд оролцсон нийт гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэх бөгөөд түүнд хуралдаан даргалагч гарын үсэг зурж баталгаажуулна.

3.2. Үндэсний хорооноос гарах шийдвэр нь зөвлөмж хэлбэртэй байна.

3.3. Үндэсний хорооны зөвлөмжийг холбогдох Засгийн газрын гишүүн, яам, Засгийн газрын агентлаг, нутгийн захиргааны байгууллага, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд хүргүүлэх бөгөөд эдгээр байгууллага, албан тушаалтан зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллана.

3.4. Үндэсний хорооны шийдвэрийг холбогдох байгууллагад хүргүүлэх, хэрэгжилтэд хяналт тавьж, дүгнэх ажлыг энэ журмын 5.1-д заасан Ажлын алба хариуцан зохион байгуулна.

Дөрөв. Дэд хорооны үйл ажиллагааны зохион байгуулалт

4.1. Үндэсний хороо нь дэргэдээ Засгийн газрын тэргүүлэх чиглэлийн бодлогын асуудлыг болон томоохон төсөл, хөтөлбөрийг хариуцсан, эсхүл цаг үеийн шинжтэй тулгамдсан асуудлыг шийдвэрлэх зорилго бүхий Дэд хороог ажиллуулах бөгөөд Дэд хорооны тоо, бүрэлдэхүүнийг Ерөнхий сайд тогтооно.

4.2. Дэд хороог Үндэсний хорооны бүрэлдэхүүнд ажиллаж байгаа Улсын Их Хурлын гишүүн тэргүүлж болно.

4.3. Дэд хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагын төлөөллийг оролцуулна.

4.4. Дэд хороо нь Засгийн газрын тэргүүлэх чиглэлийн бодлого, томоохон төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, цаг үеийн шинжтэй тулгамдсан асуудлыг шийдвэрлэх зорилгоор төрийн байгууллагын үйл ажиллагааны уялдааг хангах, мэргэжлийн удирдлага, мэргэшсэн зөвлөгөөгөөр хангах чиг үүрэгтэй.

4.5. Дэд хорооны Ажлын албаны чиг үүргийг Үндэсний хорооны Ажлын алба хариуцах бөгөөд Дэд хорооны үйл ажиллагаанд тухайн салбарын асуудлыг эрхэлсэн яам, байгууллага дэмжлэг үзүүлж ажиллана.

4.6. Дэд хорооны үйл ажиллагааны хэлбэр нь хуралдаан байх бөгөөд улиралд 1 удаа хуралдана.

4.7. Дэд хорооны дарга хариуцсан чиг үүрэгтэйгээ холбоотой цаг үеийн шинжтэй, шуурхай шийдвэрлэх асуудлаар шуурхай хуралдаан зарлан хуралдуулж болно.

4.8. Дэд хорооны нийт гишүүдийн ердийн олонх оролцсоноор хуралдааныг хүчинтэйд тооцно.

4.9. Дэд хорооны хуралдаанаар хэлэлцсэн асуудлыг хуралдаанд оролцсон нийт гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэнэ. Гишүүдийн санал тэнцсэн тохиолдолд хуралдаан даргалагчийн саналаар асуудлыг шийдвэрлэнэ.

4.10. Дэд хорооны хуралдаанаар хэлэлцсэн асуудлаар санал, зөвлөмж гаргаж, Дэд хорооны дарга гарын үсэг зурна.

4.11. Дэд хорооны хуралдаанаар асуудлыг хэлэлцэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор санал, салбарын үйл ажиллагааны уялдааг хангаж, уялдуулан зохицуулах зорилгоор зөвлөмж гаргана.

4.12. Дэд хорооны хуралдаанаас гарсан саналыг Үндэсний хорооны хуралдаанд танилцуулж, шийдвэрлүүлнэ.

4.13. Дэд хорооны хуралдаанаас гарсан зөвлөмж нь шинжлэх ухааны үндэслэлтэй, тооцоо, судалгаа, нотолгоонд үндэслэсэн, цаг үеэ олсон, хэрэгжихүйц байх бөгөөд зөвлөмжийг холбогдох яам, байгууллага, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, төсөл хэрэгжүүлэгчид хүргүүлнэ.

4.14. Дэд хорооны зөвлөмжийн дагуу холбогдох байгууллагын авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаарх мэдээлэл, тайланг Үндэсний хороонд хүргүүлж, шаардлагатай тохиолдолд Үндэсний хорооны хуралдаанд танилцуулж болно.

4.15. Дэд хороо нь үйл ажиллагаагаа Үндэсний хороонд тайлагнана. Дэд хороог байгуулсан хэрэгцээ, шаардлага, зорилго хангагдсан бол Ерөнхий сайдын шийдвэрээр татан буулгана.

4.17. Хуралдааныг тэмдэглэл хөтөлж, баталгаажуулах бөгөөд түүнд хорооны нарийн бичгийн дарга гарын үсэг зурна.

4.16. Дэд хороо хуралдааны дэгээ өөрөө тогтооно.

Тав. Үндэсний хорооны Ажлын алба

5.1. Үндэсний хороо нь Ажлын албатай байх бөгөөд Ажлын албаны дарга нь орон тооны байна. Үндэсний хорооны Ажлын албаны дарга үйл ажиллагаагаа Үндэсний хорооны нарийн бичгийн даргатай уялдуулж ажиллана.

5.2. Ажлын алба дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

5.2.1. Үндэсний болон Дэд хорооны хуралдааныг зохион байгуулах бэлтгэл ажлыг хангах, шийдвэрийг албажуулан гаргаж, Үндэсний хорооны гишүүд, холбогдох байгууллагад хүргүүлэх;

5.2.2. Үндэсний хорооны хуралдааны төлөвлөгөөг боловсруулан батлуулах, хэрэгжилтийг хариуцан зохион байгуулах;

5.2.3. Үндэсний болон Дэд хорооны гишүүдийг шаардлагатай мэдээ, мэдээллээр хангах, мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх;

5.2.4. Үндэсний болон Дэд хорооноос гаргасан шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих, дүгнэх ажлыг зохион байгуулах;

5.2.5. Үндэсний болон Дэд хорооны үйл ажиллагаанд шаардагдах тайлан, мэдээ, статистик тоо баримт, лавлагааг холбогдох байгууллагаас гаргуулах, мэдээллийн сан бүрдүүлэх;

5.2.6. Үндэсний болон Дэд хорооны албан хэрэг хөтлөлтийг зохих журмын дагуу эрхлэх, хадгалах, хамгаалах асуудлыг хариуцах.

5.3. Ажлын албаны дарга, орон тооны ажилтан нь төрийн улс төрийн албан хаагч байна.

5.4. Ажлын албаны даргыг Ерөнхий сайд, Ажлын албаны ажилтныг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга томилно.

Зургаа. Бусад зүйл

6.1. Үндэсний хороо, түүний Ажлын албаны үйл ажиллагааны зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.